

3. ЕСҮСИЙН УРИЛГА....

Тэр чиний Сөхрөн Залбирсны чинь дагуу, чамайг залан чиглүүлнэ.

Гуравдугаар сарын 14, 2016 _ Эгч Кларид Есүсээс ирсэн үгс.

Есүс _ ” Би одоо төөрөлдсөн нэгэнтэй ярьж байна. Чи дайснуудынхаа дарамт дор амьдрах ёсгүй. Чи надад амьдралаа даатгахад, Би тэнгэр илчээ явуулж чамайг хамгаалуулах болно. Хэрэв чи надтай хамт байвал би чамтай өдөр бүр уулзан, чамд зааж зөвлөх болно. Би чиний бүх л замыг харуулдан, чиний хэзээ ч төсөөлж байгаагүй авьяас бэлэгүүд болон хүсэл мөрөөдөлүүд чамд төрж, чамайг гайхшруулан , чи эцэс төгсгөлгүй баяр хөөрөөр дүүрэх болно. Эдгээр нь дайснуудын чинь та нарыг хүнд хэцүү зовлонг амьдрал руу түлхэн, чамаас нуусан бүхэн юм. ”

”Энэхүү амьдралын хэв маяг нь хоромхон зуурын онцгой сэтгэгдэл төрүүлэхээс өөр ямар ч үүрдийн гавьяа шагнал үгүй, хоосон зүйл юм. Үүгээр илүү их хүчирхийлэл, өвчин шаналан, үй гуниг, үхэл зовлонг л олж авдаг. Энэ нь хэзээ ч чиний амьдралын үнэ цэнэ, жинхэнэ хайрын хэрэгцээг хангахгүй. ”

” Тиймээ, Би чиний тухай бүгдийг мэдэх ч , Би чамд хайртай хэвээр. Би чамайг надтай хамт Диваажинд байхыг хүссэн хэвээр. Тиймээ, чиний амьдрал ямар их харанхуй, харгис байсаар байгааг Би мэднэ, гэвч Өөрийнхөө дотор чамд Би орон гэр амлаж байна. Тиймээ, Надтай хамт амьдарснаар чи өдрөөс өдөрт сайхан боломжуудаар дүүрэн, сараас сард улам их хөгжин, жилээс жилд асар их аз жаргалаар дүүрэн байх болно.”

” Гэсэн хэдий ч, чи бүхэл амьдралынхаа туршид даган яваа хорон муу явдлаасаа эргэж, Над руу ирж, Надад амьдралаа даатгавал, Би чамайг гардан авч, чамайг ялалт руу хөтлөх болно. Чамайг урьд нь ялж байсан бүхнийг одоо чи ялан дийлэх болно. Чиний өнгөрсөн амьдралд байсан бүх л харамсал, хязгаарлагдмал эрх чөлөө, дарамт шахалт, өдрөөс өдөрт харанхуйлж байсан бол, одоо амьдрал чинь утга учиртай, зорилготой болох болно. ”

” Тиймээ, Миний хүү, чамайг Би аврах болно. Би ирж, чиний амьдралын хүлээсийг эвдэх болно. Би ирж, чиний тоо томшгүй шархалсан зүрхийг чинь анагаах болно. Би басамжлагдан доромжлогдон, үзэн ядагдах гэж юу болохыг биеээрээ амссан. Би сайн үйлсийн төлөө нүүр амгүй өшигчүүлж, үхэтлээ зодуулах ямар байдгыг, мөн биеээрээ мэдэрсэн. Би тийм хэрцгий амьдралаар амьдарч, тэдгээрийг Хайрын хүчээр даван туулсан. Би чамд Хайранд автан, ялан дийлэх эрхийг өгөх болно. ”

” Би чиний өнгөрсөн амьдралын тань уйтгар гуниг, гэм бурууг авч хаян, оронд нь мөрөнд чинь хувцас, гарт чинь бөгж зүүн өгнө. Би чамд төрсөн цагаас чинь эхлэн чамаас хүлгалагдсан, жинхэнэ амьдралыг буцаан өгөх болно. Тиймээ, Би чамайг өөрийгөө ч танихгүй болтол чинь өөрчилнө. Тиймээ, Би чамайг чөлөөлнө, Би чамайг хамгаалан, Өөрийн оршин буй Диваажин руу авчирна.

Чи юу хийх хэрэгтэй вэ гэвэл Миний хайр энэрэл руу эргэн ” Өнөөдрөөс эхлэн би таньд өөрийн амийг даатгая. Миний урьдын нүгэлт амьдралыг уучилаач, миний бусдад хийсэн буруу бүхнийг болон надад буруу зүйл хийсэн хүмүүсийг уучлахад минь туслаач. Есүс, зүрх сэтгэл рүү минь ирээч, миний утга учиргүй амьдралыг минь хүлээн аваач гэж би Таны өмнө сөгдөн мөргөө” гэж хэлнэ үү.

”Миний хүү, Үүнийг зүрхнийхээ угаас хэлээч, Би чамайг тэврэн авч гайхамшигт шинэ ирээдүй рүү хөтлөх болно. Тиймээ, Би чамд үүнийг амлая, чи надад амьдралаа даатга, Би чамд итгэл өгөө. Би чиний зүрх сэтгэлд үлдсэн харалган байдал, уйтгар гунигийг арилгах болно. Би чиний сэтгэлийн шархыг эдгээж , чамайг дайснуудын чинь дээгүүр тавина. Чи нүгэлт амьдралаасаа чөлөөлөгдөж, дахин айх аюул үгүй болно. ”

”Ирж, миний гараас хөтлө, чи одоо Минийх. Өнгөрсөн амьдралынхаа хүлээснээс гарч, гэрэлт шинэ өдөрүүд тийш хамтдаа алхацгаая, Над руу ир.”